

№ 1993

IntelliCom

ТАНЫ БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сүхбаатарын талбай 0/1 Сити Тауэр бизнес төв. Утас: 976-75757979

2019.11.15. № 2/33.
танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-Д

Х. Ц. Чамсүрэн
Суралт, хангилуулалт
2019.11.15
2019.11.20 - ны
Эрх зүйч
Авсан бичиг

Хүсэлт гаргах тухай

Интелликом ХХК нь 2004 онд үүсгэн байгуулагдаж, мэдээлэл холбоо, шилэн кабел, шугамын угсралт суурилуулалт, сансрын холбооны болон байгууллагын сүлжээг зохион байгуулах, харилцаа холбооны тоног төхөөрөмж нийлүүлэлт, суурилуулалтын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Хөгжлийн явцад үйл ажиллагааны чиглэлд мэдээлэл технологийн дэд бүтцийг зохион байгуулах, мэдээлэл технологид суурилсан бизнес системүүдийн хөгжүүлэлт, уул уурхайн тусгай нөхцөлийн хяналтын камер, иргэний болон үйлдвэрлэлийн барилгын галын дохиолол, ухаалаг гэрийн шийдэл болон дагалдах тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалтын ажлыг уламжлал шинэчлэлийг хослуулан амжилттай ажиллаж байна. Мөн түүнчлэн бүхий л төрлийн аж ахуйн нэгжийн хэрэгцээ шаардлагад нийцэх Ай доктор мэдээллийн технологийн үйлчилгээг (outsourcing) шинээр хөгжүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ тэлсээр байна.

2018 оноос ДАХУА брэндийн үйлдвэрлэгчтэй хамтран ажиллах гэрээт борлуулагчийн давуу эрхтэй болсон бөгөөд ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас онцгой үнийн бодлогоор ялгарч, стандартыг мөрдөн, чанарыг эрхэмлэн ажиллаж байна.

Бид, Эрдэнэс Тавантолгой ХК-аас зарласан “ХЯНАЛТЫН КАМЕР НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ” ЭТТ/201901192 дугаар бүхий тендерт оролцохоор ажлын даалгавартай танилцаж ажлын үнэлгээг газарзүйн байрлал, цаг уурын нөхцөл, техник шаардлагын дагуу бодитоор үнэлж өртөгийг тооцох явцад шилэн кабелиг "MNS 5207:2011" стандартын дагуу газрын гүнд суурилуулах угсралтын ажлыг гүйцэтгэх, төв болон хойд оффис, цанхи хотхонд камер суурилуулалтын ажлыг зэрэг явуулах өртөг нь тендерийн төсөвт бодитоор тусгагдаагүй бөгөөд төсөвт багтаан дээрх ажлыг хийх ямар ч боломжгүй болох нь тооцоололоор гарч байна.

Интелликом ХХК нь Очир Ундраа группийн охин компани бөгөөд Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй Олборлолт ХХК, Мера ХХК, Огоот ХХК, ЭкоТек ХХК-ийн дэд бүтцийн дэмжлэгтэйгээр уг ажлыг чанарын өндөр түвшинд, стандартыг мөрдөн хийж гүйцэтгэх, нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж дээр ажиллах зааварчилгаа, сургалт орох бүрэн боломжтой гэж бид харж байна.

Иймд та бүхэн уг тендерийн бичиг баримт, техникийн шаардлага, төсөвт өртөгийг эргэн харж бодит өртөгийг тооцоолон тендерийг дахин зохион байгуулахыг хүсч хүсэл илгээж байна.

Бидний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн талаараа хариу ирүүлнэ гэж найдаж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П. БАТБААТАР

М. Батбаатар
Сүүдэр
11/15